



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.5 дахь заалт, Цэргийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, 9.1.8 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяа “Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дүрэм”-ийг хавсралтын дагуу шинэчлэн баталсугай.

2. Дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Үндэсний батлан хамгаалахын их сургууль (бригадын генерал П.Жаргалан), Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн (хурандаа Б.Эрдэнэбат)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн “Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дүрэм”-ийг батлах тухай” А/179 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Н.Пүрэвдорж)-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1323100002

Батлан хамгаалахын сайдын 2023 оны
04 дугаар сарын 06 ны өдрийн
А/05 дугаар тушаалын хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХҮРЭЭЛЭНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн (цаашид “хүрээлэн” гэх) нь аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, суурь болон хэрэглээний судалгаа явуулах, захиалгат судалгааны ажил гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнгээр үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, зорилт, зэвсэгт хүчний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч батлан хамгаалахын эрдэм шинжилгээний тэргүүлэх төрийн байгууллага мөн.

1.2. Хүрээлэн нь Монгол Улсын батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үндсэн чиг үүргийнхээ хүрээнд харьяалагдаж, Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөс бодлогын удирдамжаар хангагдан, цэргийн алба бусад өдөр тутмын үйл ажиллагаа нь Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн дүрэм, журмын хүрээнд зохицуулагдана.

1.3. Хүрээлэн нь үйл ажиллагаандаа батлан хамгаалахын хууль тогтоомж, боловсрол, шинжлэх ухаан, технологийн тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрэм болон бусад дүрэм, журмыг мөрдлөг болгоно.

1.4. Хүрээлэн нь эрдэм шинжилгээний төрийн байгууллага бөгөөд улсын бүртгэлийн гэрчилгээ бүхий хуулийн этгээд байна.

1.5. Хүрээлэн нь Засгийн газрын тогтоолоор батлагдсан нэр бүхий тэмдэг, бэлгэ тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах төрийн сангийн данс хэрэглэнэ.

Хоёр. Хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1. Хүрээлэнгийн үндсэн үйл ажиллагаа нь Монгол Улсын Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний урт, дунд, богино хугацааны хөгжлийн зорилго, зорилтын хүрээнд аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэн, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлж, инновацыг нэвтрүүлэн, батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд оршино.

2.2. Хүрээлэн нь үйл ажиллагаандаа ардчилсан зарчим, хууль дээдлэх ёс, шинжлэх ухааны ёс зүй, бүтээлч хандлага, ил тод, хариуцлагатай шуурхай байдлыг удирдлага болгож, захиргааны болон эрдмийн хамтын удирдлагын зарчмыг зохистой хослуулан хэрэгжүүлнэ.

2.3. Хүрээлэн нь аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнгээр үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,

Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабыг бодлогын зөвлөмжөөр хангах эрхэм зорилгын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.3.1. аюулгүй байдлын орчны төлөв, хөгжлийн хандлага, батлан хамгаалах тогтолцооны судалгаа явуулах;

2.3.2. батлан хамгаалах бодлого, түүний хэрэгжилтийн явц, үр дүнд судалгаа, дүн шинжилгээ хийх;

2.3.3. цэргийн шинжлэх ухаан, дайн судлал, үндэсний цэргийн урлагийг хөгжүүлэх судалгаа явуулах;

2.3.4. батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх, Зэвсэгт хүчний хөгжлийг хангах цэргийн технологи, инновац, ре-инженерингийг хөгжүүлэх судалгаа явуулах;

2.3.5. цэргийн түүх, туршлага, сургамжийн судалгаа явуулах;

2.3.6. энхийг дэмжих ажиллагаа, түүний хөгжил, чиг хандлагад судалгаа явуулах;

2.3.7. батлан хамгаалах салбарын хэмжээний эрдэм шинжилгээ, судалгааны ажилд үнэлэлт дүгнэлт өгч, цаашдын чиг хандлагыг тодорхойлох, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг удирдан чиглүүлэх, үнэлж, дүгнэх.

2.4. Хүрээлэн нь дээрх чиг үүргийг дараах арга замаар хэрэгжүүлнэ.

2.4.1. суурь болон хавсарга судалгаа явуулж, захиалгат болон судалгааны бусад төслүүдийг гүйцэтгэх замаар эрдэм шинжилгээ, судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх;

2.4.2. бусад эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд хийгдэж байгаа судалгаа шинжилгээний болон сургалтын ажилд оролцох, эрдэмтдийн залуу халааг бэлтгэх;

2.4.3. олон улс, бүс нутаг, гадаад орнуудын болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран судалгаа шинжилгээний ажил явуулах, түүний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, худалдах, оюуны өмчийн эрхийг хамгаалах;

2.4.4. эрдэм шинжилгээний хурал, симпозиум, сургалт, семинар зохион байгуулах, ном бүтээл туурвих;

2.4.5. зохих зөвшөөрлийн дагуу дангаараа болон хамтран туршилт, үйлдвэрлэлийн түшиц бааз, нэгж, гарааны компани байгуулах;

2.4.6. эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг үндэслэн төрийн байгууллага, аж ахуй нэгж, Шинжлэх ухааны академийн Их, Бага чуулганд санал, зөвлөмж хүргүүлэх, үйл ажиллагааныхаа үр дүнг тогтоосон хугацаанд захиалагч болон Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, удирдлагуудад хүргэх, тайлагнах.

Гурав. Хүрээлэнгийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Хүрээлэнгийн дүрэм, бүтэц, албан тушаалын ангилал, зэрэглэлийг Батлан хамгаалахын сайд батална. Хүрээлэнгийн орон тоог Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга батална.

3.2. Хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтын үндсэн нэгж нь удирдлага, эрдэм шинжилгээ, судалгааны төв байна. Судалгааны ажлын онцлогоос хамааран төв нь дотроо судалгаа туршилтын цех, лаборатори, гарааны компани зэрэг бусад нэгжтэй байж болно.

3.3. Хүрээлэн нь захирал, дэд захирал-эрдэмтэн нарийн бичгийн дарга, референт-эрдэм шинжилгээний ажилтан, мэдээллийн мэргэжилтэн-эрдэм шинжилгээний ажилтан, төвийн дарга, ахлах эрдэм шинжилгээний ажилтан, эрдэм шинжилгээний ажилтан, гадаад хамтын ажиллагааны мэргэжилтэн, нягтлан, аж ахуйн нярав-бичиг хэргийн эрхлэгч зэрэг албан тушаалтантай байна.

3.4. Хүрээлэнгийн удирдлага нь захиргаа, зохион байгуулалт, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, санхүү, хүний нөөц, гадаад хамтын ажиллагаа, албан бичиг хэрэг хөтлөлт, цахим хуудас, мэдээллийн сан, техник хэрэгслийн үйлчилгээ, эд аж ахуйн үйл ажиллагааг хариуцна.

3.5. Шинжлэх ухаан технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон эрдэм шинжилгээний төрийн байгууллагын захирал (дарга)-ын ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан цэргийн алба хаагчийг хүрээлэнгийн захиралд нэр дэвшүүлнэ.

3.6. Хүрээлэнгийн захирлыг яамны Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Батлан хамгаалахын сайд томилж, чөлөөлнө.

3.7. Хүрээлэнгийн захирал нь боловсролын доктор болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй байна.

3.8. Хүрээлэнгийн захирал нь Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнг төлөөлөх бүрэн эрхийг эдэлж, түүнийг удирдана.

3.9. Хүрээлэнгийн дэд захирлыг яамны Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга томилж, чөлөөлнө.

3.10. Энэ дүрмийн 3.9-д зааснаар бусад цэргийн алба хаагчдыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга томилж, чөлөөлнө.

3.11. Хүрээлэнгийн ажилчин албан хаагчдыг эрдэм шинжилгээний ажилтан сонгон шалгаруулж ажиллуулах журмын дагуу Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал санал болгосноор ҮБХИС-ийн захирал томилж, чөлөөлнө.

3.12. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан нийтлэг эрх, үүрэгтэй байна.

3.13. Эрдэм шинжилгээний ажилтан, ажиллагсдын дээр дурдсанаас бусад эрх, үүрэг, ажлын уялдаа холбоо, зохион байгуулалтын асуудлыг хүрээлэнгийн дотоод дүрэм, журмаар зохицуулна.

3.14. Хүрээлэнгийн хамтын удирдлагын хэлбэр нь Эрдмийн зөвлөл⁸, Захиргааны зөвлөл байна. Захиргааны удирдлагыг захирал, дэд захирал-эрдэмтэн нарийн бичгийн дарга, референт-эрдэм шинжилгээний ажилтан, төвийн дарга нар, мэргэжил, судалгаа хөгжүүлэлтийн ажлын аргазүйн удирдлагыг төслийн удирдагчид хэрэгжүүлнэ.

3.15. Хүрээлэнгийн захирлын тушаалаар Эрдмийн болон Захиргааны зөвлөлийг томилж ажиллуулна. Энэ нь орон тооны бус хамтын удирдлагын хэлбэр байна.

Дөрөв. Эрдмийн зөвлөл

4.1. Эрдмийн зөвлөл нь хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын үндсэн чиглэлийг тодорхойлох, түүний явц, үр дүн, эрдмийн бүтээлийн талаар үнэлэлт, дүгнэлт өгөх, хүрээлэнгийн захиралд зөвлөх, холбогдох шийдвэр гаргах эрх, үүрэг бүхий эрдэм шинжилгээний ажлын хамтын удирдлагын хэлбэр байна.

4.2. Эрдмийн зөвлөлийг хүрээлэнгийн захирал даргална. Бүрэлдэхүүнд хүрээлэнгийн дэд захирал-эрдэмтэн нарийн бичгийн дарга, хүрээлэнгийн тэргүүлэх эрдмийн зэрэг, цолтой эрдэмтдээс оролцуулж, 25 хүртэл хувийг тухайн салбарын бусад эрдэмтэн судлаачид, холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдүүлж болно. Эрдмийн зөвлөл нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн 11 - 13 хүний бүрэлдэхүүнтэй байна.

4.3. Эрдмийн зөвлөлийн ажиллах үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 75-аас дээш хувь нь оролцсон тохиолдолд хуралдаж, хуралд оролцогсдын дийлэнх олонх (75 хувиас дээш) нь дэмжсэн тохиолдолд хурлаас гарах шийдвэрийг хүчинтэй тооцно.

4.4. Шаардлагатай үед Эрдмийн зөвлөлийн хуралдааныг төвийн дарга, эрдэмтэн, судлаачдыг оролцуулж өргөтгөн зохион байгуулж болох бөгөөд тэд таслах эрх эдлэхгүй.

4.5. Эрдмийн зөвлөлийн эрх, үүрэг:

4.5.1. хүрээлэнгийн судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоох, эрдэм шинжилгээний ажлын онол, аргазүйн түвшин, ач холбогдол, үр дүнг хэлэлцэж санал дүгнэлт гаргах;

4.5.2. хүрээлэнгийн эрхэм зорилгыг тодорхойлж үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

4.5.3. хэрэгжүүлэх судалгааны төслүүдийн саналыг хэлэлцэн батлах, дэвшүүлэх;

⁸ "Шинжлэх ухаан, технологийн тухай" хууль. 11.3. эрдэм шинжилгээний байгууллага нь өөрийн эрхэлсэн салбарын эрдэмтэн, мэргэжилтнийг оролцуулсан судалгаа, шинжилгээний ажлын чиглэл болон хэрэгжүүлж байгаа эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөл байгуулан ажиллуулна.

4.5.4. суурь болон хэрэглээний судалгаа, төслийн удирдагч, шинжээчдийг томилох, бүтээлд шүүмж өгөх;

4.5.5. эрдэм шинжилгээний ажлын хөтөлбөр, төслийн явц, үр дүнгийн талаар хэлэлцэж үнэлгээ, дүгнэлт өгөх, тэдгээрийн явц, гүйцэтгэлийн эцсийн үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

4.5.6. эрдэм шинжилгээний ажилтанд бүтээлийн чөлөө олгох асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах, үр дүнг хэлэлцэж дүгнэлт гаргах;

4.5.7. эрдэм шинжилгээний ажилтнуудын үйл ажиллагаа, мэргэжлийн түвшин, ажлын үр дүнд үнэлгээ дүгнэлт өгч, ур чадварын түвшин тогтоох, мэргэжил дээшлүүлэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.

Тав. Захиргааны зөвлөл

5.1. Хүрээлэнгийн захирлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах, захиргааны шуурхай удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй захиргааны зөвлөлийг ажиллуулна.

5.2. Захиргааны зөвлөлийг 7-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр Хүрээлэнгийн захирлын тушаалаар томилон ажиллуулна.

5.3. Зөвлөлийг хүрээлэнгийн захирал даргалах ба зөвлөл нь хүрээлэнгийн удирдлага, шуурхай зохион байгуулалт, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа, ажиллагсдын нийгмийн асуудал болон шагнал, урамшууллын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.4. Хурлаас тэмдэглэл гаргах ба шаардлагатай үед Хүрээлэнгийн захирал хурлын тэмдэглэлийг үндэслэн тушаал гаргана.

Зургаа. Хүрээлэнгийн захирал

6.1. Хүрээлэнгийн захирал (цаашид “захирал” гэх) нь хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, хүний нөөц, захиргаа, санхүү, төсвийн зарцуулалт болон хамт олны өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана.

6.2. Захирал нь хүрээлэнгийн үйл ажиллагааг Батлан хамгаалах яам болон Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн өмнө хариуцна.

6.3. Захирлын эзгүй байх хугацаанд албан үүргийг нь хүрээлэнгийн дэд захирал-эрдэмтэн нарийн бичгийн дарга орлон гүйцэтгэж болно. Түр орлосон албан тушаалтны шийдвэрийн хариуцлагыг захирал хүлээнэ.

6.4. Захирал нь дор дурдсан үүрэг хүлээнэ.

6.4.1. Монгол Улсын төрийн хууль, тогтоомжийн дагуу тушаал, шийдвэр гаргаж, хүрээлэнгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;

6.4.2. хүрээлэнд мөрдөх дүрэм, журмуудыг боловсруулж батлуулах, мөрдүүлэх;

6.4.3. хүрээлэнгийн алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан батлах, мөрдүүлэх, алба хаагчидтай үр дүнгийн гэрээ, шаардлагатай тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээ байгуулах, биелэлтийг дүгнэх, цуцлах;

6.4.4. шинжлэх ухааны болон бусад байгууллага, их, дээд сургуультай хамтран ажиллахад хүрээлэнг төлөөлж, судалгаа, шинжилгээний ажлын үр ашиг, чанарыг дээшлүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг хангаж ажиллах;

6.4.5. ажиллагсдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч, тогтвортой ажиллах нөхцөл, бүтээлч хамт олныг бүрдүүлэх;

6.4.6. хүрээлэнгийн гадаад харилцааны бодлогыг тодорхойлж, гадаад орны эрдэм шинжилгээний байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх.

6.5. Захирал нь дор дурдсан эрх эдэлнэ.

6.5.1. байгууллага, иргэдтэй харьцаж, эрдэм шинжилгээний ажил, техник технологи, ажил үйлчилгээний талаар гэрээ, хэлцэл байгуулах, цуцлах;

6.5.2. хүрээлэнгийн төсвөөс гадуурх орлогыг Монгол Улсын төрийн хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

6.5.3. хүрээлэнгийн төвийн дарга, албан тушаалтан, ажиллагсдыг ажилд томилох, чөлөөлөх, шагнаж урамшуулах талаар санал гаргах;

6.5.4. гадаад орны эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуультай Батлан хамгаалах яамтай зөвшилцсөний үндсэн дээр гэрээ, хэлэлцээр байгуулах;

6.5.5. хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

Долоо. Хүрээлэнгийн дэд захирал-эрдэмтэн нарийн бичгийн дарга

7.1. Хүрээлэнгийн дэд захирал-эрдэмтэн нарийн бичгийн дарга нь Хүрээлэнгийн захиралд шууд захирагдах бөгөөд нийт бие бүрэлдэхүүний шууд захирах дарга мөн.

7.2. Захирлын эзгүйд албан ёсоор орлож, түүний нэрийн өмнөөс нийт бие бүрэлдэхүүнд тушаал, үүрэг, даалгавар өгөх эрх эдэлж, энэ тухайгаа захиралд мэдэгдэнэ.

7.3. Хүрээлэнгийн төлөвлөгөөт эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гадаад орны болон олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах гэрээ, хэлэлцээрийн биелэлтийг хангуулах, төвүүдийн үйл ажиллагааг зохицуулах, эрдэм шинжилгээний ажлын нэгдсэн тайлан гаргах ажлыг зохион байгуулж, захирлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөх үүрэгтэй ажиллана.

7.4. Хүрээлэнгийн ажилтнуудын сургалт, хүмүүжил, байлдааны бэлэн байдлын болон эрдэм шинжилгээний ажлын төлөвлөлт хийх, тайлан гаргах, эрдэм шинжилгээний хурал, симпозиум зохион байгуулах, эрдмийн болон захиргааны

зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, дотоод журмыг сахиулах, нийт бүрэлдэхүүний эрэлт хүсэлт, өргөдөл гомдлыг барагдуулах ажлыг захирлын өмнө хариуцна.

7.5. Эрдэм шинжилгээний ажилтнуудыг аттестатчилалд хамруулах бэлтгэл ажлыг хангуулна.

7.6. Монгол Улсын хууль тогтоомж, удирдлагын тушаал шийдвэр, үүрэг даалгаврыг бие бүрэлдэхүүнд хүргэх ажлыг зохион байгуулж, түүний биелэлтэд хяналт тавина.

7.7. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон түүний гүйцэтгэлийн тайланг гаргана.

7.8. Хүрээлэнгийн дотоод ажлыг Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл, их сургуулийн үйл ажиллагаатай уялдуулж явуулна.

7.9. Хүрээлэнгээс зохион байгуулах эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, семинарыг онол, практикийн болон аргазүйн өндөр түвшинд явуулах бэлтгэлийг хангуулна.

7.10. Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх, зохион байгуулах, хуралдааны протоколуудтай танилцаж гарын үсэг зурна.

7.11. Хүрээлэнгийн албан хэрэг хөтлөлтөд хяналт тавьж ажиллана.

7.12. Ажилтнуудтай явуулах аргазүйн болон бусад сургалтыг төлөвлөн, удирдаж явуулна.

Найм. Эрдэм шинжилгээ, судалгааны төв

8.1. Төвийн үндсэн үүрэг нь хүрээлэнгийн эрхэм зорилго, эрдэм шинжилгээний ажлын үндсэн чиглэл, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дотоод, гадаадын ижил төрлийн байгууллагуудтай хамтран онол, аргазүйн зохих түвшинд гүйцэтгэнэ. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэлээр мэдээллийн сан бүрдүүлэхийн зэрэгцээ ахисан түвшинд судлаач бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

8.2. Төвийн дарга нарын нийтлэг үүрэг:

8.2.1. төвийн дарга нь хүрээлэнгийн захирал, дэд захирал-эрдэмтэн нарийн бичгийн даргад захирагдах бөгөөд төвийнхөө бүрэлдэхүүний шадар захирах дарга байна;

8.2.2. төвийн хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

8.2.3. төвийн ажилтнуудын судалгаа, шинжилгээний ажлын гүйцэтгэлд нь хяналт тавих;

8.2.4. эрдэм шинжилгээ, судалгааны ажилд биечлэн оролцож, хариуцсан чиглэлийн судалгаа шинжилгээний ажилд шүүмж, дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулах;

8.2.5. удирдах дээд байгууллага болон хүрээлэнгийн удирдлагаас төвийн ажилтнуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих;

8.2.6. төвийн ажилтнуудын судалгааны ажлын онол аргазүйн түвшин, гадаад хэл, компьютерын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарах;

8.2.7. ижил төстэй судалгаа, шинжилгээний ажил явуулдаг байгууллага, хүмүүстэй хамтын ажиллагааг хөгжүүлэх;

8.2.8. хамтын ажиллагаатай байгууллага, хүмүүстэй хамтран судалгааны ажил хийх гэрээний төсөл боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, үр дүнд үнэлэлт өгөх;

8.2.9. төвийн ажилтнуудын боловсруулсан эрдэм шинжилгээний ажлын тайлан, эмхэтгэл, ном, өгүүллийг хянаж, аргазүйн зөвлөгөө өгөх;

8.2.10. төвөөс зохион байгуулах эрдэм шинжилгээний хурал, семинар, ярилцлагын төлөвлөгөөг боловсруулах, бэлтгэлийг хангах, оролцох;

8.2.11. төвийн ажилтнуудын жил, хагас жил, улирал, сард хийж гүйцэтгэх ажлыг тодорхойлж, ажлын ачаалал, цаг ашиглалтыг өндөр түвшинд байлгах.

8.3. Төвийн даргын нийтлэг эрх:

8.3.1. төвийн дарга нь ажилтнаас хууль, тогтоомж, дүрэм, журам, эрхэлсэн ажлын болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

8.3.2. ажилтныхаа хөдөлмөрлөх нөхцөл, цалин хөлс, амралт, нийгмийн хамгааллын талаарх саналаа удирдлагад танилцуулах;

8.3.3. төвийн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг харгалзан сайшаах, шийтгэх саналыг хүрээлэнгийн удирдлагад уламжлах.

Ес. Эрдэм шинжилгээний ажилтан

9.1. Эрдэм шинжилгээний ажилтан нь шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь болон хавсарга судалгааны сэдэвт ажил, олон улсын судалгааны хамтарсан төсөл, хөтөлбөрт удирдагч, үндсэн гүйцэтгэгчээр ажиллах эрхтэй бөгөөд хүрээлэнгийн судалгаа, шинжилгээний эрх ашгийг тэргүүнд тавина.

9.2. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, ахлах ажилтан, дэд ажилтан, дадлагажигч ажилтан гэсэн зэрэг дэвтэй байна.

9.3. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтныг судалгааны ажлын арга барил эзэмшсэн байдал, ур чадварынх нь түвшин, ажлын үр дүнг үнэлэх, зэрэг дэвийг ахиулах зорилгоор 4 жил тутам аттестатчилалд хамруулна.

9.4. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасан нийтлэг эрх, үүрэг эдэлж, эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллахаас гадна доор дурдсан эрх, үүрэгтэй.

9.5. Эрдэм шинжилгээний ажилтны нийтлэг эрх:

9.5.1. эрдмийн зөвлөлд сонгох, сонгогдох;

9.5.2. судалгаа, шинжилгээ туршилт зохион бүтээх ажил явуулах нөхцөл бололцоогоор хангуулах, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж авах, амрах хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах;

9.5.3. хүрээлэнгийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар санал бодлоо хууль тогтоомж, дүрэмд заасан хүрээнд аль ч шатанд чөлөөтэй илэрхийлэх;

9.5.4. судалгаандаа гадаад, дотоодын шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт арга хэлбэрийг туршин хэрэглэх;

9.5.5. судалгаа, шинжилгээ, туршилт зохион бүтээх ажилдаа шаардлагатай ном, техник хэрэгсэл, материаллаг бааз, ажлын байрыг үнэ төлбөргүй ашиглах.

9.6. Эрдэм шинжилгээний ажилтны нийтлэг үүрэг:

9.6.1. гүйцэтгэж байгаа судалгаа, шинжилгээний ажлыг чанартай гүйцэтгэх;

9.6.2. өөрийн мэдлэг боловсрол, судалгаа, шинжилгээний ажлын онол аргагүй, явуулах ур чадвараа байнга дээшлүүлэх;

9.6.3. бусад эрдэм шинжилгээний байгууллага, эрдэм шинжилгээний ажилтнуудын тэргүүн туршлагыг судалж ажилдаа ашиглаж нэвтрүүлэх;

9.6.4. цэргийн болон хөдөлмөрийн сахилгыг хатуу чанд сахиж, цэргийн дүрэм, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн болон хүрээлэнгийн дүрэм, дотоод журмыг мөрдөж хөдөлмөрийн гэрээний үүргээ биелүүлэх, мэдлэг боловсрол, ажил хэрэг, ёс суртахууны хувьд бусдад үлгэр жишээ үзүүлж байх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах.

Арав. Санхүүжилт

10.1. Хүрээлэнгийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн санхүүгээр дамжуулан санхүүжүүлнэ.

10.2. Хүрээлэнгийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлыг жил бүрийн батлан хамгаалахын төсөвт тусгана.

10.3. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, судалгааны захиалгат ажлын зардлыг захиалагч байгууллага гэрээний дагуу хийнэ.

10.4. Хүрээлэн захиалгат болон гэрээт судалгааны ажлын зардал, төсвийг төрийн сан дахь өөрийн харилцах дансаар хүлээн авч төслийн удирдагч нарын саналыг үндэслэн захирал захиран зарцуулна.

10.5. Хүрээлэн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлогыг нийгэм, соёлын арга хэмжээ, шагнал урамшуулал болон дотоодын төлөвлөсөн эрдэм шинжилгээний ажлыг санхүүжүүлэх, хүрээлэнгийн материаллаг баазыг бэхжүүлэх, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, аж ахуйн үйл ажиллагааг өргөтгөхөд зохих журмын дагуу зарцуулна.

10.6. Хүрээлэн нь санхүүгийн үйл ажиллагааны тайлангаа зохих журмын дагуу Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Санхүүгийн хэлтэст гаргаж өгнө.

10.7. Бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хуримтлал буюу санг сайн дурын үндсэн дээр байгуулж болно. Сан буюу хуримтлал байгуулах журмыг тусад нь боловсруулж мөрдөнө.

Арван нэг. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Хүрээлэнгийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүрээлэнгийн удирдлага, эрдэм шинжилгээний ажилтнууд гаргах эрхтэй бөгөөд уг саналыг Захиргааны болон Эрдмийн зөвлөлийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Батлан хамгаалахын сайдад уламжлан шийдвэрлүүлнэ.

---oOo---